



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/89

Шивээговь сум

Асран хамгаалагчаар тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гэр бүлийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1, сумын Засаг даргын 2019 оны А/60 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсгийн шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр багийн иргэн Одмаагийн Идэрбатын төрсөн эх Энхжаргалын Одмаа нь өвчний улмаас 2011 онд нас барсан гачигдлыг харгалзан үзэж Сумчин овогт Намсрайн Шүрэнцэцэгийг түүний зээ хүү болох Бодонгууд овогт Одмаагийн Идэрбатын асран хамгаалагчаар тогтоосугай.

2. Асран хамгаалагч Н.Шүрэнцэцэгт хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн, 1 дүгээр багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ